


Монгол төрийн ой санамж, түүх, соёлын үнэт барилтыг хадгалан хамгаалж,
өнгөрснийг одоотой, одоог цэрэдүйтэй холбоно.

**САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ИЛДЭН ЗАСГИЙН ХОШУУНЫ
ТҮҮХЭН ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ**
(XVIII-XX зууны эхэн)

Ш.ЭРДЭНЭБАТ. АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРДЭМШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Сум, хамжлага ардын насны бутэц



Тус хошууны 1918 оны тооллогын бүртгэлээс үзвэл, сум ардын 0-16 насны өсвөр хүүхэд 20%, 18-50 насны идэр эр 64%, 50 наснаас дээш хөгшин эр 15%, хамжлага ардын 0-16 насны өсвөр хүүхэд 19%, 18-50 насны идэр эр 48%, 50 наснаас дээш хөгшин эр 33%-ийг эзэлж байжээ. Хөдөлмөрлөх насны буюу идэр насны эрчүүд дундажаас дээгүүр хувийг эзэлж байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА





Халхын дөрвөн аймгийн 86 хошууны 83 хошууны засаг ноёд нь Чингис хааны отгон хүү Тулуйн удам хойчис, тодотговол Батмөнх Даян хааны 11 хөвгүүдийн отгон хүү Гэрсэнз жалайр хунтайжийн үр хойчис, боржигин овог, хиуд ястан юм. Харин Сайн ноён хан аймгийн Бишрэлт бэйсийн хошуу, Сүжигт бэйсийн хошуу, Засагт хан аймгийн Сүжигт гүний хошууны засаг ноёд нь Ойрадын Эсэн хааны удмынхан бөгөөд Цорос овогтон юм.

Сайн ноён хан аймгийн Илдэн засгийн хошууны язгуурын түшмэл байгуулсан нь суут Богд Чингис хааны 16 дахь үеийн ач Халхын эзэн Гэрсэнз Жалайр хунтайжийн залгамжир, Боржигэд овог, хиуд яс, уг өвөг язгуурын түшмэл байгуулсан нь Сутай илдэн юм. Тус хошуунд засаг, улсын түшээ гүн Сутай илдэнгээс эхлэн засаг бэйл жүн вангийн зэрэг хэргэмтэй нийт 13 ноёд засаг суужээ.



XVIII-XX зууны эхэн үеийн Монголын нийгэм, эдийн засгийн түүхийн судалгаанд түүхэн хүн ам зүйн судалгаа чухал ач холбогдолтой. Түүхэн хүн ам зүй нь хүн амын тооны өөрчлөлт, хүн амын тархалт, нягтрал, шилжих хөдөлгөөн, төрөлт, нас баралт, хүйсийн харьцаа, хүн ам зүйн нөхөн үржихүйн байдал зэргийг задлан шинжилж, хүн ам зүйн хөгжлийн түүхэн явцыг нээх зорилготой түүхийн шинжлэх ухааны салбар шинжлэх ухаан юм.

Оросын судлаач И.М.Майскийн тооцоолсноор 1918 онд тус хошуу нь 7600 хавтгай дөрвөлжин бээр газар нутаг, 1582 хүн амтай байснаараа Сайн ноён хан аймгийн хошуудын дотор газар нутгийн хэмжээгээр арван долоод, хүн амын тоогоор Халхын 4 аймгийн хошуудын дотор жаран тавд, Сайн ноён хан аймгийн хэмжээгээр хорин гуравт тус тус орж байв.



Халхын дөрвөн аймгийн хэмжээнд 1739-1918 онд өрх ам, малын болон эр төөлүүр зэрэг хүн амын төрөл бүрийн тооллого бүртгэл 30 гаруй удаа явагдсан байдаг. Илдэн засгийн хошууны хувьд 1802, 1823, 1839, 1855, 1911 онуудад явагдсан эр төөлүүрийн данс, 1918 оны өрх ам, малын тооллогын бүртгэл байна. Эдгээр эр төөлүүрийн данс, тооллогын баримтуудаас хошууны хүн ам, малын өсөлт, хорогдол, нийгмийн болон өрхийн бүтэц, хүн амын хүйсийн болон насны ялгаа, мал сүргийн бүтэц, сүм хийдийн жасын малын тоо, хүний нэрийн нэршил зэрэг олон асуудлыг тодруулж болно.



Эр төөлүүрийн цэсэд хошууны хэргийг эрхэлж буй туслагч түшмэд, тайж нар, сум ард, тайж нарын хамжлагыг тайж нарын нэрийн доор, хошууны дөчит лам нарыг да лам, дэмч лам нараар тэргүүлүүлж, эхэн үедээ гэрийн хөвгүүдийг хамжлагын хамт бүртгэн тодорхойлж байсан бөгөөд хошууны дотоод зохион байгуулалт, сумын тоо, албан хаагчдын тоог тодруулж болно.

Эр төөлүүрийн данс 1802 он

Халхын дундах цэргийг захирах туслагч
жанжин засгийн төрийн бэйл 1
Туслагч дэд зэргийн тайж 2
Тэргүүн зэргийн тайж 2
Дэд зэргийн тайж 5
Дөтгөөр зэрэг тайж 179
Хамжлага эр 427
Сум эр 170
Бүгд лам 40

Эр төөлүүрийн данс. 1911 он

Засгийн төрийн бэйл 1
Туслагч дэд зэргийн тайж 2
Туслагч дөтгөөр зэрэг тайж 1
Тэргүүн зэргийн тайж 1
Дэд зэрэг тайж 1
Захирагч занги бөгөөд дөтгөөр зэрэг тайж 1
Гутгаар зэрэг тайж 1
Дэд зэргийн тайж 5
Дөтгөөр зэрэг тайж 176
Хамжлага эр 466
Сум эр 150
Бүгд лам 40



XVIII-XX зууны Монголын нийгэм нь давхраажлын үндсэн үзүүлэлт болсон өмч хөрөнгө, орлого, засаглал ба хүч чадлыг эзэмшсэн ноёд язгууртан, тайж нар, мэдлэг ба боловсролыг шингээсэн лам нар, хэнд харьяалагдаж, ямар алба үүрэг гүйцэтгэж байгаагаараа ялгагдсан хамжлага, сум, шавь ард гэсэн давхраанд хуваагдаж байв. Дээрх нийгмийн давхраанууд Илдэн засгийн хошуунд ч мөн адил байжээ.


он төргүй нэгэн тооллогын баримт байгаа нь



АЗАР

МОНГОЛ УЛС

1918 онд нийгмийн давхаргын эзлэх хувь



1918 онд тус хошууны хүн амд лам нарын эзлэх хувь хамгийн өндөр буюу 29 %, удаад нь хамжлага 26%, тайж нар 24%, сум ард 21%-ийг эзэлж байжээ.

